



НИЙСЛЭЛИЙН БАЯНГОЛ ДҮҮРГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2021 оны 10 сарын 25 өдөр

Дугаар А/457

Улаанбаатар хот


“Залуус-25” сууц өмчлөгчдийн холбоог
шинээр бүртгэж, гэрчилгээ олгох тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.6.л, 29.2, Сууц өмчлөгчдийн холбооны эрх зүйн байдал, нийтийн зориулалттай орон сууцны байшингийн дундын өмчлөлийн эд хөрөнгийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1.1 дэх заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Баянгол дүүргийн 3 дугаар хорооны Залуус хотхонд байрлах 25 дугаар байрны оршин суугчдын 2021 оны 07 дугаар сарын 05-ны өдрийн бүх гишүүдийн хурлын шийдвэр, холбогдох материалыг үндэслэл болгон “Залуус-25” сууц өмчлөгчдийн холбоог шинээр бүртгэж, гэрчилгээ олгох ажлыг зохион байгуулсугай.

2.Нийтийн зориулалттай орон сууцны байшингийн дундын өмчлөлийн эд хөрөнгийн хэвийн байдлыг хангах, сууц өмчлөгчдийн эрх, ашиг сонирхлыг хамгаалах, дундын өмчлөлийн эд хөрөнгийн эзэмшил, ашиглалт, арчлалт, хамгаалалтыг эрхлэн хариуцаж ажиллахыг “Залуус-25” сууц өмчлөгчдийн холбоонд үүрэг болгосугай.

3.Дүүргийн сууц өмчлөгчдийн холбоодын бүртгэлд нэмж бүртгэх, захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Тохижилт, Нийтийн аж ахуйн хэлтэст үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА  Ө.СУМЪЯАБААТАР